

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ 7 САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 07 дүгээр сарын 10

Мандалговь хот

## **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан мэдээлэл, түүнийг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг орон нутагт чанартай, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүний хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлагуудыг болоод Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”-д заасан үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтыг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнд явцын хяналт шинжилгээг тусгай удирдамж гарган аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 газар, хэлтэс, агентлагт зохион байгуулан зөвлөн тусалж ажиллалаа.

## **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Дундговь аймагт 2024 оны 07 сарын байдлаар хяналтад хэрэгжиж буй шийдвэрийн 121 заалтыг хяналтад авч хэрэгжүүллээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны 07 дугаар сарын хэрэгжилтийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс авч нэгтгэн, Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор баталсан БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ-д заасан үнэлгээ өгөх зааврын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 121 заалтын биелэлт 84,95 хувьтай байна.

## **Гурав. Дүгнэлт**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тусгай удирдамж, шалгуур үзүүлэлтийг урьдчилан гаргаж холбогдох газруудад хүргүүлэн, хяналт-шинжилгээний явцад болон дууссаны дараа ажил сайжруулах чиглэлээр тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох газруудад хүргүүлж хэрэгжилтийн явцад хяналт тавьж заавар, зөвлөмж нэгдсэн удирдлагаар хангаж ажилласны үр дүнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 84,95 хувьтай хэрэгжсэн байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад шийдвэрийн 20 заалтыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд энэ чиглэлээр холбогдох агентлагуудад чиглэл өгч ажиллах нь зүйтэй.

Цаашид үр дүнг жилийн эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд тусгай шалгуур үзүүлэлт боловсруулан дүгнэх бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн сарын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр хэлтэс, агентлагууд анхаарч ажиллах шаардлагатай.

Хэрэгжилт гаргах, хяналт тавих явцад гарч буй хүндрэл нь хугацааны хувьд болоогүй буюу нэг удаагийн шинжтэй заалтуудыг сар бүр тооцох боломжгүй байдал үүсгэж байна.

### **Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / Зөвлөмж /**

Санал:

Хэрэгжилт гаргах, хяналт тавих явцад гарч буй хүндрэл нь хугацааны хувьд болоогүй буюу нэг удаагийн шинж агуулсан заалтуудыг сар бүр тооцоход шат шатандаа хүндрэлтэй байдал үүсгэж байна. Жишээлбэл: Өвөлжил, хаваржилттай холбоотой, цас зудтай холбоотой, мөн санхүүжилтийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах, газрын ерөнхий төлөвлөгөө батлах зэрэг жилд 1 удаа хэрэгжих заалт олон давхцахаас гадна сар бүр тооцоход хүндрэлтэй, маргаантай асуудлууд үүсч байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлээд нэг удаагийн шинжтэй, хэрэгжилт тогтмолжсон заалтуудыг нэг бүрчлэн шүүн үзэж хяналтаас хасуулах саналыг дээд газарт хүргүүлж байгаа хэдий ч нүсэр олон заалтын хэрэгжилт сар бүр гаргасаар байгаа тул саналыг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.

## **ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**